



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/011/НА-СТА-ТХН

| | |
|---|--|
| <p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он</p> | <p>Санхүү, нийцлийн газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Аудитор: Ж.Мөнхбилгүүн Утас: 261628 Цахим хаяг: munkhbilguunj@audit.gov.mn Нийслэл-Аудит ХХК-ийн захирал: Т.Сугарсүрэн Утас: 976-99115395 Цахим хаяг: info@niislelaudit.mn Аудитор: С.Сэрчхорол Утас: 976-99007519 Цахим хаяг: serchchorols@niislelaudit.mn</p> |
|---|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.04.25 № 07/1581
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төслийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлд ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төслийг хэрэгжүүлэх 9336-МН дугаартай 100.0 сая ам.долларын зээлийн гэрээг Монгол Улсын Засгийн газар болон Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд, 7039-МН дугаартай 10.0 сая ам.долларын санхүүжилтийн гэрээг Монгол Улсын Засгийн газар болон Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдөр тус тус байгуулсан ба Монгол Улсын Их Хурлаар тус зээлийн хэлэлцээрүүдийг 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр соёрхон баталж 2024 онд төсөл хэрэгжүүлэх нэгж нь байгуулагдсан байна.

Тайлант онд төсөл хэрэгжүүлэх нэгж нь төслийн зорилгын хүрээнд төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулах болон, Багц-1, Багц 2 болон Багц 3-ийн тендер шалгаруулах ажилд гадаад зээлийн эх үүсвэрээс 3,381,230.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал

байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Багц 1-1 хэсэг Улаанбаатар-Өндөрхаан чиглэлийн 68 км авто зам, Багц 1-2 хэсэг Арвайхээр-Баянхонгор чиглэлийн 35 км авто зам, Багц 2-1 хэсэг Улаанбаатар- Арвайхээр чиглэлийн 105 км авто замын засварын ажил, Багц 2-2 хэсэг буюу Хархорин-Цэцэрлэг чиглэлийн 40 км авто замын засварын ажил, Багц 2-3 хэсэг буюу Цэцэрлэг-Тосонцэнгэл чиглэлийн 50 км авто замын засварын ажил болон Гичгэний голын 90 у/м гүүр, Бэлхийн голын 30.2 у/м гүүр болон Хануйн голын 75.3 у/м гүүрийн засварын ажлуудын нарийвчилсан зураг төслийг шинэчлэх ажлын даалгавар батлуулах хүсэлтийг Зам, тээврийн яаманд тавьж, гүүрийн ажлын даалгавруудыг батлуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 3 бүрэлдэхүүн, хэсгийн хүрээнд 27 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| Мөрийн дугаар | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---------------|--|----------------|-------------------------|
| | | | /төгрөгөөр/ |
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | - | 2,569,560,015.45 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | - | 2,569,244,015.45 |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | - | 2,569,244,015.45 |
| 31210 | Төгрөг | - | 12,688,268.78 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 12,688,268.78 |
| 31220 | Гадаад валют | - | 2,556,555,746.67 |
| 31221 | Төрийн сангийн харилцах | - | 2,556,555,746.67 |
| 33 | АВЛАГА | - | 316,000.00 |
| 33402 | Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/ | - | 316,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | - | 117,770,059.73 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | - | 117,770,059.73 |
| 39200 | Биет хөрөнгө | - | 111,172,798.93 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | - | 109,198,420.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | - | (21,522,944.42) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | - | 24,661,160.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | - | (1,163,836.65) |
| 39300 | Биет бус хөрөнгө | - | 6,597,260.80 |
| 39301 | Программ хангамж | - | 8,000,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | - | (1,402,739.20) |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | - | 2,687,330,075.18 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | - | 316,000.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 316,000.00 |
| 41300 | Өглөг | - | 316,000.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 316,000.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | - | 2,687,014,075.18 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | - | 2,687,014,075.18 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | - | 2,687,014,075.18 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 2,687,014,075.18 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | - | 2,687,330,075.18 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| | | | /төгрөгөөр/ |
|---------------|--|----------|-------------------------|
| № | Балансын зүйл | Өмнөх он | Тайлант он |
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | - | 3,386,060,872.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | - | 3,386,060,872.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | - | 3,386,060,872.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 3,381,230,000.00 |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | - | 3,381,230,000.00 |
| 120009 | Бусад орлого | - | 4,830,872.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | - | 728,766,812.39 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | - | 728,766,812.39 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | - | 728,766,812.39 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | - | 541,088,934.78 |
| 210101 | Үндсэн цалин | - | 541,088,934.78 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | - | 67,636,116.85 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | - | 45,992,559.46 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | - | 5,410,889.35 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | - | 2,705,444.67 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | - | 2,705,444.67 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | - | 10,821,778.70 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | - | 38,256,298.66 |
| 210304 | Байрны түрээс | - | 38,256,298.66 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | - | 13,059,096.93 |
| 210401 | Бичиг хэрэг | - | 9,279,460.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 3,779,636.93 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | - | 2,323,200.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 2,323,200.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | - | 14,880,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 14,880,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | - | 27,433,644.90 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 27,433,644.90 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 24,089,520.27 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | - | 24,089,520.27 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | - | 2,657,294,059.61 |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | - | 30,087,081.48 |
| 145001 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз | - | 30,087,081.48 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | - | 367,065.91 |
| 225004 | Гадаад валютын ханшийн зөрүүний гарз | - | 367,065.91 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | - | 2,687,014,075.18 |
| VI-I | Засгийн газрын хувь оролцоо | - | - |
| VI-II | Хяналтын бус хувь оролцоо | - | - |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| | | | /төгрөгөөр/ |
|---------------|--|----------|-------------------------|
| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | - | 3,386,060,872.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | - | 3,386,060,872.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | - | 3,386,060,872.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 3,381,230,000.00 |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | - | 3,381,230,000.00 |
| 120009 | Бусад орлого | - | 4,830,872.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | - | 704,677,292.12 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | - | 704,677,292.12 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | - | 704,677,292.12 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | - | 541,088,934.78 |
| 210101 | Үндсэн цалин | - | 541,088,934.78 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | - | 67,636,116.85 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | - | 45,992,586.96 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | - | 5,410,904.35 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | - | 2,705,364.67 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | - | 2,705,452.17 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | - | 10,821,808.70 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | - | 38,256,298.66 |
| 210304 | Байрны түрээс | - | 38,256,298.66 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | - | 13,059,096.93 |
| 210401 | Бичиг хэрэг | - | 9,279,460.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 3,779,636.93 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | - | 2,323,200.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 2,323,200.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | - | 14,880,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 14,880,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | - | 27,433,644.90 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 12,242,906.90 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 15,190,738.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | - | 2,681,383,579.88 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | - | 141,859,580.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 141,859,580.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 141,859,580.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 141,859,580.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | - | (141,859,580.00) |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | - | 29,720,015.57 |
| 14 | Бусад эх үүсвэр | - | 30,087,081.48 |
| 145001 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз | - | 30,087,081.48 |
| 25 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | - | 367,065.91 |
| 250001 | Гадаад валютын ханшийн зөрүүний гарз | - | 367,065.91 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | - | 2,569,244,015.45 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 2,569,244,015.45 |

.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---------------------------------|-------------------------|--|
| 2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл | - | - | - |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - |
| Тайлангийн үеийн үр дүн | - | - | - |
| 2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл | - | - | - |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - |
| Тайлангийн үеийн үр дүн | - | 2,687,014,075.18 | 2,687,014,075.18 |
| 2024 оны 12 сарын 31-р үлдэгдэл | - | 2,687,014,075.18 | 2,687,014,075.18 |

2.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|-------------|--|-----------------------|-------------------------|---------------------------|--------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 858,000,000.00 | 846,536,872.12 | 11,463,127.88 | 98.7 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 857,000,000.00 | 846,536,872.12 | 10,463,127.88 | 98.8 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 857,000,000.00 | 846,536,872.12 | 10,463,127.88 | 98.8 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 545,000,000.00 | 541,088,934.78 | 3,911,065.22 | 99.3 |
| 210101 | Үндсэн цалин | 545,000,000.00 | 541,088,934.78 | 3,911,065.22 | 99.3 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 69,484,000.00 | 67,636,116.85 | 1,847,883.15 | 97.3 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 46,000,000.00 | 45,992,586.96 | 7,413.04 | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,871,000.00 | 5,410,904.35 | 460,095.65 | 92.2 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,935,500.00 | 2,705,364.67 | 230,135.33 | 92.2 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,935,500.00 | 2,705,452.17 | 230,047.83 | 92.2 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,742,000.00 | 10,821,808.70 | 920,191.30 | 92.2 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 38,450,000.00 | 38,256,298.66 | 193,701.34 | 99.5 |
| 210304 | Байрны түрээс | 38,450,000.00 | 38,256,298.66 | 193,701.34 | 99.5 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 14,500,000.00 | 13,059,096.93 | 1,440,903.07 | 90.1 |
| 210401 | Бичиг хэрэг | 9,500,000.00 | 9,279,460.00 | 220,540.00 | 97.7 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 500,000.00 | - | 500,000.00 | 0.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,000,000.00 | 3,779,636.93 | 220,363.07 | 94.5 |
| 210404 | Ном, хэвлэл | 500,000.00 | - | 500,000.00 | 0.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 137,171,800.00 | 136,182,780.00 | 989,020.00 | 99.3 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 110,000,000.00 | 109,198,420.00 | 801,580.00 | 99.3 |
| 210602 | Тавилга | 24,671,800.00 | 24,661,160.00 | 10,640.00 | 100.0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,500,000.00 | 2,323,200.00 | 176,800.00 | 92.9 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 15,000,000.00 | 14,880,000.00 | 120,000.00 | 99.2 |
| 210702 | Дотоод албан томилолт | 15,000,000.00 | 14,880,000.00 | 120,000.00 | 99.2 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 37,394,200.00 | 35,433,644.90 | 1,960,555.10 | 94.8 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 21,394,200.00 | 20,242,906.90 | 1,151,293.10 | 94.6 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 16,000,000.00 | 15,190,738.00 | 809,262.00 | 94.9 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,000,000.00 | - | 1,000,000.00 | 0.0 |
| 220001 | Барилга байгууламж | 1,000,000.00 | - | 1,000,000.00 | 0.0 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 858,000,000.00 | 3,381,230,000.00 | (2,523,230,000.00) | 394.1 |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 858,000,000.00 | 3,381,230,000.00 | (2,523,230,000.00) | 394.1 |
| 350004 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 858,000,000.00 | 3,381,230,000.00 | (2,523,230,000.00) | 394.1 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 2,539,523,999.88 | (2,539,523,999.88) | 0.0 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | - | - | - | - |
| 650010 | Удирдах | 1 | 1 | - | 100.0 |
| 650011 | Гүйцэтгэх | 11 | 9 | 3 | 81.8 |
| 650012 | Үйлчилгээ | 3 | - | 3 | 0.0 |

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ3.2 Аудитаар илэрсэн нийт 6,485.8 мянган төгрөгийн зөрчил²-д 1 зөвлөмж өглөө**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | /мянган төгрөгөөр/ | | | | | | | | | |
|--|-------------|----------------|--------------------|-----|-----------------|-----|----------|----------------|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Ажилтнуудад олгосон 1-3 дугаар сарын цалинг Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд сар бүрээр нь бус нэг удаа олгосон цалингаар тайлагнаснаар 6,485.8 мянган төгрөгийн НДШ-ийг дутуу тооцож алдаатай тайлагнасан. | 1 | 6,485.8 | | | | | 1 | 6,485.8 | | | | |
| Дүн | 1 | 6,485.8 | | | | | 1 | 6,485.8 | | | | |

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлаар 8,592,312.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | /мянган төгрөгөөр/ | | | | | |
|--|-------------|-----------------|--------------------|-----|-----------------|-----|----------|-----------------|
| | | | Үүнээс | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээнээс 64,944.0 мянган төгрөгийн 2 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна. | 1 | 64,944.0 | | | | | 1 | 64,944.0 |
| Дүн | 1 | 64,944.0 | | | | | 1 | 64,944.0 |